



**АВТОМАШИНЫ СЭЛБЭГ, ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2022 оны 03-р сарын 30-ны өдөр

№ММ-А-2022-330

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийг үндэслэл болгон, дор дурдсан талууд харилцан тохиролцож байгуулав. Үүнд:

Нэг талаас 9011272059 тоот Улсын бүртгэлийн, 5446139 тоот регистрийн дугаартай “Моннис Моторс” ХХК, (Цаашид “Нийлүүлэгч” тал гэх),

Хаяг: Ниссан төв, Нарны зам-13, 5-р хороолол, 2-р хороо, СБД, Улаанбаатар хот,
Утас: 75851111, Факс: 323248.

Нөгөө талаас, 5021111 тоот регистрийн дугаартай “Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ” (Цаашид “Худалдан авагч” тал, хамтад нь “талууд” гэх)

Хаяг: УБ, БГД, 17-р хороо, Амарсанаагийн гудамж
Утас: 75112020

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Нийлүүлэгч нь Худалдан авагчид гэрээний хавсралтад заасан үзүүлэлт, тоо ширхэг бүхий шинэ Автомашины сэлбэг, хэрэгсэл (цаашид “Сэлбэг, хэрэгсэл” гэх)-ыг нийлүүлэх, Худалдан авагч Сэлбэг, хэрэгсэлийн үнийг гэрээнд заасны дагуу бүрэн төлж, хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ.
- 1.2. Энэхүү гэрээнд талууд нь хүсэл зорилгоо бүрэн тусгасан бөгөөд тэгш эрхийн үндсэн дээр, гэрээний бүх зүйл заалттай бүрэн танилцаж хүлээн зөвшөөрч, уг гэрээг байгуулж байна.

1.3.1- Хавсралт-1 Сэлбэг захиалгын хуудас.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

- 2.1. Гэрээний зүйл болох сэлбэг, хэрэгсэл нь хавсралтад заасан шинж,чанар, үзүүлэлт, тоо хэмжээгээр байна.
- 2.2. Худалдан авагч нь гэрээний үнийг бүрэн хэмжээнд төлсөн тохиолдолд Автомашины сэлбэг хэрэгсэлийг хүлээлгэн өгөхийг хүлээн зөвшөөрч байна.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ХИЙХ НӨХЦӨЛ

- 3.1. Энэ гэрээний дагуу Нийлүүлэгчийн нийлүүлэх, Худалдан авагчийн хүлээн авахаар тохиролцсон сэлбэг, хэрэгсэлийн үнэ болон төлөлт хийгдэх хуваарийг доорхи хүснэгтэд харуулав. Уг үнэд НӨАТ багтсан болно.

Д/д	Нэр төрөл	Нэгж үнэ	Тоо ширхэг	Төлвөл зохих дүн
1	Сэлбэг, хэрэгсэл	20,000,000₮	багц	20,000,000₮
Нийт				20,000,000₮

- 3.2. Сэлбэг хэрэгсэлийн үнийг Худалдан авагч нь Нийлүүлэгчийн банкны харилцах дансанд бүрэн шилжүүлсэн, үүнийгээ нотолсон баримтыг Нийлүүлэгчид хүлээлгэн өгсөн, эсхүл Нийлүүлэгчийн кассат бэлнээр тушаасан тохиолдолд төлбөр хийгдсэнд тооцно. Ийнхүү төлбөрийг бүрэн хэмжээнд төлсөн тохиолдолд Худалдан авагч нь сэлбэг, хэрэгсэлийг хүлээн авна.

ДӨРӨВ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Нийлүүлэгч тал дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ:
 - 4.1.1. Гэрээний дүнг бүрэн төлөхийг Худалдан авагчаас шаардах эрхтэй.
 - 4.1.2. Техникийн бүрэн бүтэн байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй сэлбэг, хэрэгсэлийг Худалдан авагчид нийлүүлнэ.
 - 4.1.3. Худалдан авагч сэлбэг хэрэгсэлийн үнийг бүрэн төлсөн бол сэлбэг, хэрэгсэлийг акт үйлдэн Худалдан авагчид хүлээлгэн өгнө.
 - 4.1.4. Сэлбэг, хэрэгсэлийг Худалдан авагчид хүлээлгэн өгөхөөс өмнөх хариуцлагыг Нийлүүлэгч хариуцна.
 - 4.1.5. Худалдан авагчид сэлбэг, хэрэгсэлийг хүлээлгэн өгснөөс хойшхи хугацаанд үүссэн аливаа асуудлыг Нийлүүлэгч хариуцахгүй.
 - 4.1.6. Худалдан авагчаас энэ гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй. Хэрэв Худалдан авагч гэрээний үүргээ зөрчсөн бол уг зөрчлийг арилгах буюу гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахтай холботой бий болсон, баримтаар нотлогдох зардал, учирсан хохирлоо Худалдан авагчаас нөхөн төлүүлэх эрхтэй.
- 4.2. Худалдан авагч тал дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ:
 - 4.2.1. Худалдан авагч нь энэ гэрээний 2.1-д заасан сэлбэг, хэрэгсэлийг 3.1-д заасан үнээр худалдах авахыг эргэлт буцалтгүйгээр зөвшөөрч байна.
 - 4.2.2. Сэлбэг, хэрэгсэлийн үнийг гэрээнд заасны дагуу төлж дуусгах үүрэгтэй.
 - 4.2.3. Гэрээний үнийг бүрэн төлсөн тохиолдолд Сэлбэг, хэрэгсэлийг Нийлүүлэгчээс шаардах эрхтэй. Энэ хүртэл хугацаанд Нийлүүлэгчээс сэлбэг, хэрэгсэлийг хүлээн авахаар шаардах эрхгүй.
 - 4.2.4. Сэлбэг, хэрэгсэлийг хүлээн авахдаа бүрэн бүтэн байдлыг сайтар нягталж Хүлээлцэх актыг заавал үйлдэж, гарын үсэг зурна.
 - 4.2.5. Хэрэв сэлбэг, хэрэгсэлийг хүлээлцэх үед эвдрэл гэмтэл илэрвэл уг сольж өгөхийг Нийлүүлэгчээс шаардах эрхтэй.
 - 4.2.6. Нийлүүлэгчээс энэ гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй. Хэрэв Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн бол уг зөрчлийг арилгах буюу гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахтай холботой бий болсон, баримтаар нотлогдох зардал, учирсан хохирлоо Нийлүүлэгчээс нөхөн төлүүлэх эрхтэй.

ТАВ. БАТАЛГАА

- 5.1. Нийлүүлэгч төл сэлбэг хэрэгсэлийг үйлдвэрлэх явцад үүссэн материал, дизайны доголдол болон ажиллагсдын буруутай үйл ажиллагаанаас сэлбэг хэрэгсэлд учирсан гэмтэл зэргийг бүрэн хариуцаж гэмтэл, доголдлыг өөрийн зардлаар арилгана.
- 5.2. Сэлбэг хэрэгсэлийг актаар хүлээн авсанаас хойш үйлдвэрлэх явцад үүссэн материал, дизайны доголдол болон нийлүүлэгчийн ажиллагсдын буруутай үйл ажиллагаанаас сэлбэг хэрэгсэлд учирсан гэмтлээс бусад эвдрэл, гэмтлийг худалдан авагч тал өөрөө хариуцна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдсэн бөгөөд талууд гарын үсэг зурж, хуулийн этгээд бол тэмдэг дарснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 6.2. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах бол энэ талаар нөгөө талдаа мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож бичгээр байгуулснаар нэмэлт өөрчлөлт нь хүчинтэй болно.
- 6.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд харилцан зөвшилцөж асуудлыг шийдвэрлэнэ. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртсөн тал нь нөгөө талын өмнө ямарваа хариуцлага хүлээхгүй.
- 6.4. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад маргаан гарвал талууд эвийн журмаар харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв шийдэлд хүрэхгүй бол Монгол Улсын Шүүхээр, Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 6.5. Энэхүү гэрээ нь талууд сэлбэг, хэрэгсэлийн үнэ болон бусад өр, авлагыг бүрэн барагдуулж дуусах хүртэл, сэлбэг, хэрэгсэлийг хавсралтад заасан тоо хэмжээний дагуу бүрэн нийлүүлэх хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 6.6. Энэхүү гэрээ нь гуравдагч талд нууц байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

Нийлүүлэгчийг төлөөлж:
“Моннис Моторс” ХХК-ийн

Санхүү хариуцсан захирал Д.Ринчиндорж



.....

“Моннис Моторс” ХХК-ийн

Сэлбэг хариуцсан менежер Б.Батгэрэл


.....

Худалдан авагчийг төлөөлж:
“Радио Телевизийн Үндэсний
Сүлжээ УТҮГ”
Хангамж үйлчилгээний
Албаны дарга Э.Энхгэрэл


.....

MONNIS
MONNIS MOTORS

Sukhbaatar District - 2 Sun Road-13, Nissan Center,
Ulaanbaatar 14251, Mongolia,
Утас: (976) 75851111

Сэлбэг захиалгын
хуудас

Огноо	Хуудас
2022-03-30 14:56:22	1
Захиалгын дугаар	
ORD0005177	



Худалдан авагч:

Хүлээн авагч:

РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ УТУГ

КОМПАНИ: РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ УТУГ

НЭР: РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ УТУГ
УТАС: 75112020

Үнийн санал №	Улсын №	Арлын №	Захиалгын №	Жин
QT0002494	5342УБК	JN1VBUI32Z0003897		90.00

№	Сэлбэгийн код	Сэлбэгийн нэр	Бэлэн байдал	Тоо	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	31020-1XT4A	TRANSAXLE ASSY-	Захиалга	1.00	pcs	16,825,300.00	16,825,300.00
2	KLE52-00004	03ATF(CVT)	Захиалга	2.00	pcs	170,800.00	341,600.00
						Нийт дүн	15,606,272.72
						Нийт татвар	1,560,627.28
						Төлөх дүн	17,166,900.00

Тайлбар:

Бэлэн бус сэлбэгийг ажлын 25-40 хоногт захиалгаар нийлүүлнэ.

Гэвч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор сэлбэг нийлүүлэх дээрх тов нь тодорхойгүй хугацаагаар сунгагдаж байгааг анхаарна уу.

Захиалагчийн зүгээс захиалга цуцлах, авахаас татгалзсан тохиолдолд сэлбэгийн нийт үнийн дүнгийн 30%-ийг эргүүлэн олгохгүй.

Захиалга хүлээн авагч:



Мөнгөнсүх.Мөнхбаатар/MT5050/
94110047

Захиалгыг зөвшөөрсөн захиалагч:

РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ УТУГ

Огноо	Хуудас
2022-03-28 17:05:00	1
Захиалгын дугаар ORD0005136	



Худалдан авагч:

Хүлээн авагч:

РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ УТУГ	КОМПАНИ: РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ УТУГ НЭР: РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ УТУГ УТАС: 75112020
---------------------------------------	--

Үнийн санал №	Улсын №	Арлын №	Захиалгын №	Жин
	5590УББ	NT30-205136		3.72

№	Сэлбэгийн код	Сэлбэгийн нэр	Бэлэн байдал	Тоо	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	11720-6N20A	РЕМЕНЬ	Бэлэн	1.00	pcs	151,300.00	151,300.00
2	15208-31U0B	ТОСНЫ ШҮҮР	Бэлэн	2.00	pcs	33,900.00	67,800.00
3	23300-8H300	MOTOR-STARTER	Захиалга	1.00	pcs	1,563,500.00	1,563,500.00
4	22680-CA000	METER-AIR FLOW	Захиалга	1.00	pcs	1,038,500.00	1,038,500.00
5	01553-09321	ДУНД КНОП	Бэлэн	5.00	pcs	1,400.00	7,000.00
6	24319-C9915	ГАЛ ХАМГААЛАГЧ	Бэлэн	2.00	pcs	2,500.00	5,000.00
						Нийт дүн	2,575,545.45
						Нийт татвар	257,554.55
						Төлөх дүн	2,833,100.00

Тайлбар:

Бэлэн бус сэлбэгийг ажлын 25-40 хоногт захиалгаар нийлүүлнэ.

Гэвч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор сэлбэг нийлүүлэх дээрх тов нь тодорхойгүй хугацаагаар сунгагдаж байгааг анхаарна уу.

Захиалагчийн зүгээс захиалга цуцлах, авахаас татгалзсан тохиолдолд сэлбэгийн нийт үнийн дүнгийн 30%-ийг эргүүлэн олгохгүй.

Захиалга хүлээн авагч:



Мөнгөнсүх.Мөнхбаатар /MT5050/
94110047

Захиалгыг зөвшөөрсөн захиалагч:

РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ УТУГ